



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 606

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Радио телевизийн үндэсний сүлжээ” улсын төсөвт үйлдвэрийн газар, салбар нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 37,700,000.00 (гучин долоон сая долоон зуун мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Золбаяр, “Радио телевизийн үндэсний сүлжээ” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал С.Цагаанхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

30-r huraldaan

132003682

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 2 ны өдрийн
№ 6 дугаар тогтоолын хавсралт

**РАДИО ТЕЛЕВИЗИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ХАРЪЯА
САЛБАР НЭГЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Байгууллагын нэр	Автомашин нэр, улсын болон хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Говь-Алтай РТСГ	Тоёота клугер, суудлын, 19-08 ГАУ, АСУ200021275	2001/2014	239000	19,200,000.00	19,200,000.00	-	-	3,500,000.00
2	Дорнод РТСГ	Тоёота рав-4, 60-03 ДОР, суудлын, АСА210287785	2004/2014	174095	18,500,000.00	18,500,000.00	-	-	3,200,000.00
Нийт дүн									
					37,700,000.00 (гучин долоон сая долоон зуун мянга)	37,700,000.00 (гучин долоон сая долоон зуун мянга)			6,700,000.00 (зургаан сая долоон зуун мянга)